



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№101 /315/

2022.05.30

Цаг үе, үйл явдал

## ШУА-ТАЙ ХАМТРАН “ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи (ШУА)-ийн хооронд 2020 онд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Туршлага солилцох өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Өдөрлөгийг ШУА-ийн ерөнхийлөгчийн зөвлөх, академич Т.Ган-Эрдэнэ, БХЯ-ны ШУТЗ-ийн

эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) дэд профессор хурандаа Д.Содномцог нар нээн үг хэлж, ШУА-ийн Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга, доктор (Ph.D) С.Баяннасан хөтлөн явууллаа. Тус өдөрлөгт Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан

хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Цэргийн төв эмнэлгийн 50 гаруй эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд оролцож, ШУА-ийн харьяа Археологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн,

Биологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Математик, тоон технологийн хүрээлэн, Физик, технологийн хүрээлэн, Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцов. Энэхүү арга хэмжээний үеэр захирлууд хүрээлэнгийнхээ эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа болон лабораториудыг батлан хамгаалахын эрдэмтэн судлаачдад танилцуулан харилцан мэдээ, мэдээлэл туршлага солилцоноос гадна цаашид хамтран ажиллах чиглэлээ тохирсны дагуу төлөвлөгөө гарган баталгаажуулж, хэрэгжүүлэхээр боллоо.

Батлан хамгаалах салбарын судлаачид шинжлэх ухаанч, асуудлын мөн чанарт хандсан, цаашид хамтран ажиллах чиглэлээр олон чухал асуултыг асууж хэлэлцүүлэг өрнүүлсэн нь өдөрлөгийн үйл ажиллагааг улам сонирхолтой болгосон бөгөөд оролцогчид сэтгэл хангалуун байгаагаа дурдацгааж байв.

Өмнө нь батлан хамгаалахын нийгмийн ухааны чиглэлийн эрдэмтэн судлаачид Шинжлэх ухааны академийн харьяа Нийгмийн ухааны чиглэлийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцсан юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	🌧️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,121.00	3,126.0
EUR 🇪🇺	3,360.0	3,380.0
CNY 🇨🇳	463.00	466.00
RUB 🇷🇺	39.00	45.00
JPY 🇯🇵	24.55	24.75
KRW 🇰🇷	2.50	2.52

### ЗУРХАЙ



2022.05.30 /ДАВАА ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 30

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН  
МОГОЙ САРЫН ЗУРГААН  
ЦАГААН МЭНГЭТЭЙ  
ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**

Эрлэг лугаа учирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
04.59-20.41

**Барилдлага:**

Идэр  
Шүтэн барилдлага:  
Хуран үйлдэхүй  
Суудал: Огторгуй

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, уул овоо тахирад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## ИНЖЕНЕРИЙН ЦЭРГҮҮД “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ



### Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Батлан хамгаалах салбараас хэрэгжүүлэх “Эко-Ногоон хотхон” төслийн хүрээнд ангийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээн сайжруулах, цэцэрлэгжүүлэх, мод, бут, зүлэг тарих, модоо хамгаалах хашаа татах, усалгааны систем хийх ажлуудыг эрчимтэйгээр зохион байгуулж ажил хэрэг болгоод байгаа юм.

Төслийн хүрээнд 6000 гаруй мод, суулгац тарих бөгөөд үүнд нарц

20, гацуур мод 55, хар мод 60, монос 123, хус 50, агч 50, хайлаас 3922, голт бор 123, улаан яргай 50, өрөл 20, цэцэг 100, улиас 118 суулган ургуулах, арчлан хамгаалах ажлыг гүйцэтгэж байна. Энэ үеэр хурандаа Г.Эрдэнэбаяр захиралтай Зэвсэгт хүчний 234 дүгээр ангиас 1500 гаруй хайлаас илгээж ангийн байнгын байрлалыг үе шаттайгаар ногоон хотхон болгох ажилд дэмжлэг үзүүлсэн юм. Энэхүү ажилд ангийн байнгын бүрэлдэхүүн болон хугацаат албаны дайчид гар бие оролцож байн

## “БҮХ ХАЙРЫГ ГЭР БҮЛДЭЭ” БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн соёл хүмүүжлийн ажлын сэтгэл зүйн хангалтын тусгай төлөвлөгөөний дагуу “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын бяцхан үрсэд зориулсан “Бүх хайраа гэр бүлдээ” баярын өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээг нээж ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар үг хэлж баяр хүргэсэн юм. Мөн хүүхэд багачуудыг цэрэг-эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх зорилгоор ангийн үйл ажиллагаатай танилцууллаа.

“Бүх хайраа гэр бүлдээ” баярын

арга хэмжээнд ХЦАХ-дын гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолт, үлгэрийн баатруудын мэндчилгээ, хүүхэд багачуудын дунд “Манцуйтай тамирчин”, “Аваа, ээжээ би чадна”, “Авьяаслаг багачууд”, “Миний гэр бүл” гар зургийн уралдаан, “Бид чадна” хөгжөөнт буухиа зэрэг тэмцээнүүдийг зохион явууллаа. Тус тэмцээнүүдэд хүүхэд багачууд идэвх санаачилгатай оролцож хурд хүч, авьяас чадвараараа бусдыгаа манлайлсан хүүхдүүдийг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж хүрэлцэн ирсэн хүүхэд бүрийг гарын бэлгээр урамшуулав.

Дэслэгч Р.БИЛЭГ



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 531,678,528

Эдгэрсэн

Нийт: 502,505,590

Нас барсан

Нийт: 6,310,915

Цахим шууданд

**ОРОН НУТАГТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА**



Тус арга хэмжээний хүрээнд Завхан аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Ерөнхий боловсролын "Дэвшил", II арван жилийн сургуулиудад "Монгол цэрэг-энхийн үйлсэд" сэдэвт сургалт сурталчилгааны ажлыг хорооны командын байрын дарга дэд хурандаа Т.Армия, ССХА-ны Үлээвэр найрал хөгжмийн салааны бие бүрэлдэхүүн амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн "Монгол цэрэг-энхийн үйлсэд" сэдэвт сургалт сурталчилгааны ажил 5 дугаар сарын 29-ийг хүртэл үргэлжилж, Улиастай сумын төв талбайд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын цэргийн ёслолын жагсаалыг нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр зохион байгуулав.

**Зэвсэгт хүчний 325 дугаар анги**

"Олон улсын энхийг сахиулагчид"-ын баярын өдрийн хүрээнд орон нутагт Зэвсэгт хүчин, цэргийн анги байгууллагаа сурталчлах олон талт ажлуудыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэхээр төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулав.

**ЭВИЙН ӨРГӨӨ-ЭНХИЙН ГҮЙЛТ -2022 ГАЛТ БАМБАРЫГ 281 ДҮГЭЭР БАЙГУУЛАМЖИЙН АЛБА ХААГЧИД ХҮЛЭЭН АВЧ БУУХИАЛАВ**

Даян дэлхийн эв найрамдлын төлөө уриатай "Эвийн өргөө-Энхийн гүйлт" Олон улсын марафонд оролцож буй баг тамирчид энэ сарын 27-ны өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хүрэлцэн ирснийг 281 дүгээр байгууламжийн алба хаагчид тосон авч цааш буухиаллаа.

Галт бамбарыг буухиалах гүйлтийн баг тамирчдад амжилт хүсэж баяр хүргэх хүндэтгэл арга хэмжээг энэ хүрээнд зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд 281 дүгээр байгууламж, сумын аж ахуй нэгж, албан байгууллагын албан хаагчид болон Ерөнхий боловсролын сурагчид, иргэд оролцлоо.



**"МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ" СЭДЭВТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАН ЯВУУЛЛАА**



**Зэвсэгт хүчний 350 дүгээр анги**

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан Налайх дүүргийн 5 дугаар хорооны 103 дугаар сургууль, 153 дугаар цэцэрлэгийн хүүхэд багачуудад "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт нээлттэй сурталчилгааны ажлыг энэ сарын 26-ны өдөр

зохион байгуулан явууллаа. Энэ хүрээнд бага бууны зэвсгийн үзэсгэлэнг дэлгэн үзүүлж, урлагийн номерыг тоглож, гардан тулааны үзүүлэх тоглолт, жижиг бүлгийн тактикийн ажиллагааг үзүүлэн сонирхууллаа.

Мөн иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд тус хорооны иргэн Б.Янжмаагийн гэрийг засаж, гэрт нь шинэ гадна, дотор

цагаан бүрээс бүрж, хашааг цэвэрлэн, эвдэрч хэмхэрсэн зүйлийг засаж янзлан, хашааны гадна талын өнгө үзэмжийг сайжруулахын зэрэгцээ өрхийн хэрэгцээнд зориулан хүнсний бүтээгдэхүүнийг гардуулан өгч, хашаанд нь мод тарьж өглөө.

**Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ**

**"ЭХ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ-ДАРХАН ХИЛ"**



**Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**  
Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Эх орны үзэсгэлэнт байгаль-дархан хил аяллыг зохион байгууллаа.

Аялалд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд амжилттай оролцож энхийн байруудад шалгарсан багудын 33 сурагч, удирдагч багшийг хамрагдсан бөгөөд тус "Эх орны үзэсгэлэнт байгаль-дархан хил" аяллыг Хилийн цэргийн 0245 дугаар анги болон Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулсан юм.

**Хошууч Ж.ЦЭРЭНЧИМЭД**

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЦЭРЭГ-СПОРТ "ДӨЛ-2022" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО**



**Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**

Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "ДӨЛ-2022" цогцолбор тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн аварга, аймгийн аварга шалгаруулах гэсэн 2 үе шаттай амжилттай зохион байгуулж явууллаа. Эхний шатыг 5 дугаар сарын 5-9-ны өдрүүдэд аймгийн 12 жилийн сургалттай Ерөнхий боловсролын 12 сургууль, Политехникийн коллежийн нийт 13 сургуулийн 2100 сурагчид хамрагдсан бол хоёрдугаар шат буюу аймгийн засаг даргын нэрэмжит аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулав. Хоёрдугаар шатны тэмцээнийг аймгийн төв талбай, Цагдаагийн газрын сургалтын төвийг түшиглэн амжилттай зохион байгууллаа. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Монгол Улсын



Их хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нар хүрэлцэн ирж тэмцээнийг үзэж сонирхон, баг тамирчдад амжилт хүслээ.

II дугаар шатны тэмцээнд 7 сумын 13 сургуулийн 169 сурагчид хурд хүч, авхаалж самбаа, авьяас чадвар, мэдлэг

оюунаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн "Хас" тасаг шалгарч шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, дурсамж, мөнгөн шагнал, дэд байранд Биндэр сумын Ерөнхий боловсролын

сургуулийн "Шонхор" тасаг, гутгаар байранд Өлзийт тосгоны Ерөнхий боловсролын сургуулийг "Өлзийт" тасаг, тусгай байранд Хэрлэн сумын Ерөнхий боловсролын "Тэмүүжин" цогцолбор сургуулийн "Сүлд" тасгууд тус тус шалгарч өргөмжлөл, дурсамж, мөнгөн шагналаар шагнагдлаа.

**"ЭНХИЙН ҮЙЛС-2022" НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ**



**Зэвсэгт хүчний 331 дүгээр анги**

Баян-Өлгийн аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтарсан "Энхийн үйлс-2022" нээлттэй хаалганы өдөрлөгийг энэ сарын 25-ны өдөр аймгийн төв талбайд зохион байгууллаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгт Баян-Өлгий аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд, бие бүрэлдэхүүн, НҮБ-ын болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон энхийг сахиулагчид, аймгийн Ерөнхий боловсролын

сургуулиудын багш сурагчид, ард иргэд оролцлоо.

Өдөрлөг Баян-Өлгий аймгийн засаг даргын орлогч С.Хоноев үг хэлж, энхийг сахиулагчид Икей /1921-1939/ баатрын хөшөөнд цэцэг өргөснөөр эхэллээ.

Үргэлжлүүлээд Зэвсэгт хүчний 331 дүгээр анги байлдааны зэвсэг техник, уулын цэргийн хувцас, тусгай хэрэгсэл, энхийг сахиулагчдын зургагт самбар, "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" гар зургийн үзэсгэлэн, цэргийн мэргэжлийн ном, сонин, сэтгүүлийн үзэсгэлэн зэргийг дэлгэн үзүүлэхийг зэрэгцээ ангийн

байлдааны салбаруудын алба хаагчид гардан тулааны үзүүлэх тоглолт, өндрөөс олс ашиглан буух үзүүлбэр үзүүлж, эмнэлгийн албаны бие бүрэлдэхүүн өдөрлөгийг үзэж сонирхсон хүмүүсийн амин үзүүлэлтүүдийг үзэж, дархлаажуулах витамин, нэг удаагийн амны хаалтыг тараалаа.

Мөн аймгийн онцгой байдлын газрын алба хаагчид аврах ажиллагааны үзүүлбэр үзүүлж, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд чиг үүргээ танилцуулж, анги байгууллагаа сурталчлан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцлоо.

Түүнчлэн Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын аймгийн хэмжээнд зохион байгуулсан тэмцээн уралдааны шагнал гардуулах ёслолын арга хэмжээ энэ үеэр зохион байгуулсан юм.

**Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД**

